МЭДЭЭ · 2025 оны 10-р сарын 21

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙЛЭЭ



Завхан аймгийн прокурорын газар нь тус аймгийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Байгалиа хамгаалъя" арга хэмжээг зохион байгуулжээ.

Тус арга хэмжээний хүрээнд Завхан аймгийн Тосонцэнгэл суманд үйл ажиллагаа явуулдаг ойн мэргэжлийн байгууллага, хөрөө рам ажиллуулдаг иргэдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт, шалгалт хийсэн байна.

Шалгалтын үр дүнд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 4 хөрөө рамын үйл ажиллагааг түр зогсоож, илэрсэн зөрчил, дутагдал, цаашид анхаарах асуудлын талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулан, иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийг тайлбарлан

таниулж, мэдээлэл өгч ажилласан байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/527